



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 598

Улаанбаатар хот

“Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн
2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6
дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Увс АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2
дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2020 оны бизнес төлөвлөгөө болон
худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж
ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй
 гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг
нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг
холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал
Ц.Цэдэнбалд даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого
төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001027

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн
598 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

“УВС АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2020 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

Д/Д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	2019 он		2020 оны Төлөвлөгөө	2020 төл-г 2019 гүй-тэй харьцуу лсан хувь	зөрүү /2020 төл-2019 гүй/ төл-2019 гүй/
				Төлөвлөгөө	ХБГ			
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.төг	1 171 538,3	1 181 818,2	1 230 969,4	1 272 727,3	103	41 757,90
	Үүнээс: Улсын чанартай зам засвар, арчлалтын ажил	мян.төг	904 344,58	1 090 909,1	1 090 909,1	1 181 818,2	108	90 909,10
	Орон нутгийн чанартай зам засвар, арчлалтын ажил	мян.төг	267 193,72	90 909,1	140 060,3	90 909,10	65	(49 151,20)
2	Нийт орлого	мян.төг	1 271 159,87	1 181 818,2	1 230 969,4	1 272 727,3	103	41 757,90
3	Нийт зардал	мян.төг	1 257 911,47	1 170 318,2	1 218 168,8	1 255 642,3	103	37 473,50
	Үүнээс: Удирдлагын зардалд	мян.төг	187 423,58	223 417,8	227 511,4	239 726,6	105	12 215,23
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	13 248,40	11 500,00	12 800,60	17 085,00	133	4 284,40
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	11 923,6	10 350,0	11 520,5	15 376,5	133	3 855,96
6	Төсвийн төлбөр	мян.төг	228 999,10	213 795,4	247 848,3	240 729,2	97	(7 119,06)
7	Ногдол ашиг	мян.төг	1 347,70	1 150,00	1 602,18	1 267,65	79	(334,53)
8	Нийт ажиллагагсдын тоо	хүн	45	46	46	46	100	-
9	Нийт цалингийн сан	мян.төг	384 938,1	403 600,0	424 381,1	411 598,4	97	(12 782,70)
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	712,8	731,2	768,8	745,6	97	(23,16)
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0,99	0,99	0,99	0,99	100	(0,00)
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	25 939,9	1 500,0	1 500,0	9 850,0	657	8 350,00
13	Нийт авлага	мян.төг	73 829,48	108 970,0	105 800,0	80 000,0	76	(25 800,00)
14	Нийт өглөг	мян.төг	489 919,35	534 521,50	520 821,50	500 651,50	96	(20 170,00)
	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	мян.төг	59 267,80	103 870,0	90 170,0	70 000,0	78	(20 170,00)
	Хойшлогдсон орлого. УОО	мян.төг	329 141,60	-	329 141,6	180 000,0	55	(149 141,60)
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	430 651,6	430 651,5	430 651,5	430 651,5	100	0

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
59.8 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“УВС АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (мян.төг)	Нийт дүн (мян.төг)
1	Гагнуурын аппарат	ш	1	3000,0	3000,0
2	Сандал	ш	10	300,0	3000,0
3	Зөөврийн компьютер	ш	1	3500,0	3500,0
4	Шүүгээ	ш	1	350,0	350,0
	Нийт дүн				9 850,0